



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2015 оны 09 сарын 22 өдөр

Дугаар 4/94

Чингис

Зардал гаргах тухай

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам "Нийтийн хэв журам хамгаалах /код 400/ журам"-ын код 400.5.1.а дахь заалт, "Байгууллагын даргын тушаал гаргах /код 136/ журам"-ын 136.4.2-ын "е" дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ардын хувьсгалын түүхт 94 жил, Хэнтий аймаг байгуулагдсаны 92 жилийн ойн баярын арга хэмжээний ёслол, хамгаалалтыг аймгийн Засаг даргын тамгын газартай хамтран төлөвлөгөө, удирдамжийн дагуу зохион байгуулахыг нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Д.Батхүү, төлөвлөлт, зохион байгуулалтын тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Д.Дэлэг нарт даалгасгай.

2. Баяр наадмын арга хэмжээнд ажиллах алба хаагчдын хоолны зардалд туслах аж ахуйгаас 2 /хоёр/ хонь, 3 /гурав/ ямаа, нийт 5 /тав/ толгой мал олгож зарлагадахыг ахлах нягтлан бодогч, цагдаагийн хошууч Ж.Баатарт зөвшөөрсүгэй.

3. Тушаалыг бүрэлдэхүүнд танилцуулсугай.

ДАРГА ЦАГДААГИЙН  
ХУРАНДАА П.ОРОСТОГОО



005697